

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**

Өдөр -10  
Шөнө -20

**АСУУДАЛ**

**СҮХ ДАЛАЙТАЛ МОНГОЛЧУУД  
АМГАЛАН**

III нүүрт

**УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА**

**Б.БОЛОР: ЗАСГИЙН ГАЗАР “ЭРДЭНЭТ”-ИЙН  
49 ХУВИАС ТАТГАЛЗСАНЫГ БИ ОДОО Ч  
ЗӨВ ШИЙДВЭР ГЭЖ ҮЗДЭГ**

IV нүүрт

**Дугаарын 60 мөр**  
Үүрэн телефоны  
компаниуд иргэдээ  
битгий шулаач  
Н.БАТЗАЯА

Манайхан их гангарах дургтай улс. Түүний нэг илрэл нь дэлхийн олон улс оронд салбартай хувцас, гоёл чимэглэл тэр бүү хэл цахилгаан бараанууд манай улсын томоохон худалдааны төвүүдийн лангуун дээр заларч, аль хэдийнэ хэрэглэгчидтэй болоод амжсан. Тэр дундаа орчин үеийн харилцааны гол хэрэгсэл болсон гар утсыг өргөн ашиглаж буй. Хамгийн сүүлийн жишээ гэхэд л үндэстэн дамнасан корпораци гэгдэх “Apple” компани iPhone 7, iPhone 7 Plus гар утасныхаа загварыг өнгөрсөн есдүгээр сард танилцуулсан ч манай улсад тун удахгүй худалдаалагдаж эхэлсэн. Нөгөө талаас үүнийг дэлхий ертөнц глобалчлагдаж, улс орны гадаад харилцаа хөгжсөнтэй ч холбон тайлбарлаж болно. Гэхдээ манай улсын иргэд дэлхийн техник технологийн хөгжилтэй хамт алхаж яваа ч өндөр үнээр худалдаж авсан гар утсаа бүрэн ашиглаж чадалгүй түүнийгээ боол нь болоод явах нь олонтой.

Үргэлжлэл нь III нүүрт

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

**ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ**

## ИХ ХУРЛАА УГТАЖ, ХУРАЛДСАН АН-ЫН ҮЗХ ЯМАР АСУУДАЛ ЯРИВ...



ЖОТГОН

Их хурлаа угтаж, өчигдөр АН-ын ҮЗХ хуралдаанаар хуралдаанаар Их хурлаараа хэ-

лэлцэх намын дүрмийн шинэчлэлийг хэлэлцсэн байна. Харин ҮЗХ-ноос баталсан шинэчлэлийг Их хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд зарим асуудлаар фракциудын байр суурийг нэгтгэхээр болсон

Гэрээ зургийг Г.АРГУУЖИН

гэнэ. Их хуралдаанд татвараа төлсөн төлөөлөгчийг оролцуулах юм байна. ҮЗХ-ны хурлын үеэр АН-ын зарим гишүүдийн байр суурийг сонсоноо хүргэе.

Үргэлжлэл нь V нүүрт

**АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ**



### М.ӨЛЗИЙБАТ: УЛААНБААТАРТ ГАЗАР ХӨДӨЛБӨЛ ГАЙТИЙН СҮЙРЭЛ ШИГ Л ЮМ БОЛНО

Н.ПУНЦАГБОЛД

Одон орон, геофизикийн судалгааны төвийн Газар хөдлөлт судлах секторын эрхлэгч М.Өлзийбаттай ярилцлаа.

-Саяхан Өмнөговь аймгийн Цогтцэций суманд газар хөдөлсөн

талаар мэдээлэл гарсан. Бүр өндөржүүлсэн бэлэн байдал зарласан гээд байгаа шүү дээ? -Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг, Тавантолгойн уурхайн орчимд газар хөдөллөө. Хүчний хувьд бага. Магнитудаар нь ярих юм бол хамгийн хүчтэй нь 3.6-тай хөдлөлт болсон юм.

Үргэлжлэл нь VI нүүрт

**ДЭЛХИЙ**

### МАТТЕО РЕНЦИГИЙН

### эрин үе дууслаа



Б.ДАВАА

Италид 1948 онд батлагдсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, сенатчдын эрх мэдлийг хязгаарлах эсэх талаархи бүх нийтийн санал хураалт болов.

Үргэлжлэл нь VII нүүрт



**БИД ТАНЫ АЖЛЫГ ХҮНДЭЛНЭ**



**Алдаж болохгүй алтан боломж**

Dell –ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аваарай.



**ХААН банк**

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2462.00	2475.00	ФУНТ	3073.00
ЕВРО	2567.00	2638.00	РУБЛЬ	36.80
ИЕН	21.43	21.80	ЮАНЬ	357.30

**Худалгаа хөгжлийн банк**

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2464.00	2478.00	ФУНТ	3104.00
ЕВРО	2594.00	2683.00	РУБЛЬ	37.73
ИЕН	21.38	22.12	ЮАНЬ	357.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар







# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



## ИХ ХУРЛАА УГТАЖ ХУРАЛДСАН АН-ЫН ҮЗХ ЯМАР АСУУДАЛ ЯРИВ...

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Төгсгөл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Л.Болд: Намын даргыг нийт гишүүдийн сонголтоор тодруулах хэрэгтэй



*/УИХ-ын гишүүн/*

Яг одоо Их хуралд бэлтгэх ажлын хэсгийн тайланг сонсч байна. Дүрэмд орох өөрчлөлтүүдийн талаар гишүүд саналаа илэрхийлж, ҮЗХ-аар саналаа нэгтгэж байна. Ийнхүү саналаа нэгтгээд орчихвол Их хурал дээр хэлэлцэх үйл явц арай хялбар байх болов уу гэдэг үүднээс хуралдаж байна. Намын дүрмийн хувьд олон санал гарч байгаа. Гэхдээ ажлын хэсгээс тодорхой дүрмийн өөрчлөлтийн санал гараад байна. Тиймээс яг түүн дээр тулгуурлан ажиллаж байна. Мэдээж хүн бүрийн анхаарал татаж байгаа асуудал бол намын гишүүнчлэлийг нээх асуудал байгаа. Өөрөөр хэлбэл, гишүүд цахимаар болон биечлэн ирэх гээд олон хэлбэрээр АН-д гишүүнээр элсэх асуудал нэлээд анхаарлын төвд байна. Түүнчлэн бүх шатанд дотоод ардчиллыг нэвтрүүлэх буюу нийт гишүүдээсээ намын удирдлагуудыг сонгох эсэх гээд олон асуудал хөндөгдөж буй. Ер нь намын даргыг нийт гишүүдийн сонголтоор тодруулах хэрэгтэй. Нийт гишүүдээр сонгуулах явцад дургай хүн нь нэр дэвшээд явах уу, намын дээд шатны аль нэг

байгууллага тодорхой шалгуур тавиад сонгон шалгаруулалт хийгээд, тодорхой тооны нэр дэвшигчийг сунгаанд оруулах уу гэдгийг хоёр тал нэлээд сайн ярилцаж байж шийдэх байх. Нэлээд маргаж байгаа.

Д.Зоригт: ҮЗХ-ны гишүүдийн тоог нэмэхээр ярилцаж байна



*/УИХ-ын гишүүн асан/*

-Намын Их хурлаар хэлэлцэх асуудлын тов, жагсаалтаа хэлэлцэж байна. Маргааш болох их хурал 1200 гаруй төлөөлөгчтэй том хурал учир хурлын зохион байгуулалтын асуудал буюу мандатын, редакцийн, тооллогын комиссуудаа байгууллаа. Түүнчлэн маргааш /өнөөдөр/ хэлэлцэх гол асуудлууд болох намын даргын улс төрийн илтгэл, намын шинэчлэлийн ажил болоод үндсэн үзэл баримтлал ямар байх тухай асуудлыг өнөөдрийн /өчигдөр/ хуралдаанаар хэлэлцэж байна. Намын даргыг улс орон даяар нийт намын гишүүдийнхээ дунд сунгаа маягаар явуулж олонхийн санал авсан хүнийг сонгох байх. Өөрөөр хэлбэл, хуучин Их хурлын 1200-1300 хүн эсвэл ҮЗХ-оос сонгогчидог байсныг болих гэж байна. Сонгууль өгөх эрхтэй АН-ын бүх гишүүдийн саналаар сонгогддог болно гэсэн үг. Тиймээс намын даргыг сонгох асуудал илүү нээлттэй болно. Намын Их хурлаар дүрэм

өөрчлөгдсөний дараа намын даргын сунгааны тов зарлагдах юм. Шинэ дүрмийн төсөлд ҮЗХ-ны гишүүдийн тоог 228-380 болгож нэмэгдэхээр тусгасан байсан. Ийнхүү гишүүдийн тоог нэмж, хоёр жил тутамд 50 хувьд нь шинэчлэл хийхээр яригдаж байна. Ийнхүү гишүүдийн тоог нэмж байгаа нь хувь хүнээс эсвэл цөөн хэдэн фракцийн хоорондоо яриад асуудлыг шийддэг байдлаас ангижирч байгаа юм.

С.Дэмчиг: Их хурлаар намын даргын асуудлыг ярихгүй



*/АЗХ-ны дарга/*

-Маргааш /өнөөдөр/ манай намын Их хурал хуралдах гэж байна. Энэ удаагийн хурлаас хамгийн гол нь намын үндсэн дүрмийн шинэчлэлийг хүлээж байгаа. Энэхүү хүлээлт нь намын жирийн гишүүд дэмжигчдээс эхлээд төлөөлөгчид ч байх шиг байна. Ер нь бол сайн дүрэм батлагдаж байж, энэ намын дотоод эв нэгдэл, ил тод байдал, харилцааны тогтолцоо, санхүүжилтийн журам гэх мэт олон асуудал сайжрах учиртай. Тиймээс ирэх өдрүүдэд болох Их хурлаар дүрмээ сайтар хэлэлцэж байж батлах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. АН-ын ҮЗХ-оос АН-ын Үндсэн дүрмийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсэг сүүлийн 10 гаруй хоног хуралдсан.

Ажлын хэсгийн боловсруулсан дүрмийн төслийг ажлын хэсгийн ахлагч Ш.Түвэндорж яг одоо танилцуулж байна. Улмаар эндээс гарсан дүрмийн тодорхой төслийг маргаашийн /өнөөдөр/ Их хуралруу оруулах байх. Мэдээж Их хурлын төлөөлөгчид тэрхүү дүрмийн төслийг хэрхэн яаж батлах эсэх бүрэн эрх нь байгаа. Тиймээс дүрэм яаж ч батлагдаж болох юм. Надад ирсэн мэдээлээр Их хурлаар зөвхөн намын үндсэн дүрэм батлана. Тухайн үндсэн дүрэмд намын нийт гишүүдийн саналаар намын даргыг сунгаагаар тодруулна гэж заасан байгаа. Тиймээс маргааш намын даргын асуудлыг ярихгүй.

П.Галиндэв: АН дарга байхгүй ийм удаан хугацаанд явж болохгүй



*/АН-ын шинэчлэлийн хөдөлгөөний тэргүүн/*

-Өнгөрсөн хугацаанд тал талд намын үндсэн дүрмийг боловсруулах, хүмүүс ажиллаж байсан. Үндсэндээ сар гаруйн хугацаанд ҮЗХ-оос байгуулагдсан АН-ын дүрмийн ажлын хэсэг сайтар ажилласан. Гэхдээ АН-ын шинэчлэл гэдэг зүйл ганцхан сарын хугацаанд эсвэл хоёр сар боловсруулаад хийх ажил биш. Тиймээс илүү урт хугацаанд сууж, ажиллах шаардлага тулгарч байгаа. Маргааш /өнөөдөр/ намын Их хурлаар намынхаа гишүүдтэйгээ дүрмийнхээ асуудлыг нэлээд

сайн ярилцах болно. Цаашид ч намын шинэчлэлийн асуудал бүтэн жилийн хугацаанд үргэлжлэх ёстой гэж харж байгаа. Намын даргын хувьд маш олон байр суурь яригдаж байгаа юм. Тухайлбал, намын нийт гишүүдээс намын марафоноор даргыг сонгох ёстой. Эсвэл намын Их хурлаар сонгох ёстой гэх зэргээр яригдаж байна. Миний хувьд Их хурлаар намынхаа даргыг тодруулах ёстой гэж үзэж байгаа. АН дарга байхгүй ийм удаан хугацаанд явж болохгүй. Дарга байхгүй орон нутгийн сонгуульд оролцоод амжилт үзүүлж чадсангүй. Хэрвээ энэ байдлаараа удаан үргэлжилбэл нам эзэнгүйдэх байдал харагдаж байна. Тиймээс Их хурлаараа намын даргыг сонгох нь зөв. Түүний дараа намын шинэчлэлийн ажлыг сонгогдсон дарга нь үргэлжлүүлээд явах нь зүйтэй.

Г.Баярсайхан: Шинэчлэл хийж чадна гэж найдаж байгаа



*/АН-ын ҮЗХ-ны гишүүн/*

-ҮЗХ-ны энэ удаагийн хурлаар маргааш /өнөөдөр/ болох Их хурлын тооллого болоод мандатын комисс гээд зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж байна. Түүнчлэн ҮЗХ-ны татварын асуудлыг ярилцаж байна. Өөр онц содон зүйл яриагүй. Их хурлаар намын даргын асуудлыг ярихгүй. Энэ удаагийн Их хурлаас намын дүрмийн шинэчлэлийг

хийх, нэгдсэн шинэ зохион байгуулалтад орохыг л хүлээж байна. Ер нь АН-ын шинэчлэлийг боломжийн хэмжээнд хийхийг л оролдох болно. Шинэчлэл хийж чадна гэж найдаж байгаа. Манай намын дүрэм болоод үндсэн зохион байгуулалтад дорвитой өөрчлөлт хийхгүй бол болохгүй байна. Болохгүй байна гэдгийг өнгөрсөн сонгуулиудын үр дүн харуулчихлаа шүү дээ. Тиймээс шинэчлэлийг нэлээд анхаарах хэрэгтэй. Залуучууд, эмэгтэйчүүд болоод ахмадууд гээд бүх намын дэргэдэх олон нийтийн байгууллагуудын гээд бүх гишүүдийн саналыг үндэслэх болно. Олуулаа хэлэлцвэл буруугүй гэдэг зарчим дээр тулгуурлан өөрчлөлт хийж байгаа.

А.Бакей: Намын даргын сунгааг зохион байгуулах журмыг ярилцаж байна




*/УИХ-ын гишүүн асан/*

-Өнөөдрийн хурлаар АН-ын шинэчлэлийн хөтөлбөр гэх бодлогын баримт бичгийг батлахаар хуралдаж байна. Түүнчлэн АН-ын үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, төслийг хэлэлцэж батлана. Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт орж байгаагай холбоотойгоор зарим нэмэлт дүрэм, журмыг хэлэлцэж байна. Онцлох зүйл гэвэл намын даргад нэр дэвшигчдийн сунгааг зохион байгуулахтай холбоотой дүрэм, журмыг мөн ярилцаж байна.



### ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ





# ДЭЛХИЙ

## Нарендра Модри Энэ оны хүчирхэг хүн болж магадгүй

“TIME” сэтгүүлийн уншигчдын дунд явуулсан санал асуулгаар 2016 онд нэр алдар нь олонд түгсэн удирдагчид, уран бүтээлчид, улстөрчдийн дундаас Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модри хамгийн олон санал авчээ. Сэтгүүлийн редакторууд “Оны шилдэг хүн”-ийг тодруулах боловч дэлхий дахин эдгээр хүмүүсийг хэрхэн үнэлж байгааг харгалзан үзэх ажээ. Ням гарагт болсон санал асуулга дуусах үед Н.Модри 18 хувийн санал авч тэргүүлсэн бол түүнтэй “хамгийн ширүүн өрсөлдсөн” АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама, АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан Дональд Трамп, “Wikileaks”-ийг үүсгэн байгуулагч Жулиан Ассанж нар тус бүр долоон хувийн санал авсан байна. Сүүлийн хэдэн сарын хугацаанд Н.Модри дэмжигч энэтхэгчүүдийн тоо эрс өсчээ. Тэрбээр уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын гэрээг соёрхон баталж, Энэтхэгийн эдийн засагт хүндрэл учруулж буй 500, 1000 рупийн мөнгөн дэвсгэртүүдийг устгах ажилд анхааран ажиглаж байгаа юм. “TIME” сэтгүүл оны хамгийн нөлөө бүхий хүнийг жил бүр тодруулдаг билээ.



Төгсгөл.  
Түүрүүч нь I нүүрт

Улмаар санал асуулгын дүн өчигдрөөс эхлэн олон нийтэд тодорхой болж эхэлсний зэрэгцээ дэлхийн топ мэдээллийн сайтуудын онцлох үйл явдлын нэгээр нэрлэгдэж байв. Тэгвэл санал тооллогын үйл ажиллагаа 90 орчим хувьтай байхад санал асуулгад оролцогсдын 60 хувь нь “Үгүй”, үлдсэн 40 орчим хувь нь Үндсэн хуулийг шинэчлэхийг дэмжсэн байжээ. Тус улсын Үндсэн хууль 1948 онд батлагдсан бөгөөд шинэчлэх санаачилгыг Ерөнхий сайд Маттео Ренци гаргасан байдаг. Тийм ч учраас Ерөнхий сайд суудалдаа үлдэх, эс үлдэх нь гагцхүү энэ удаагийн санал асуулгын үр дүнгээс хамаарах байлаа. Нэг үгээр хэлбэл, санал асуулгаар иргэдийн ихэнх нь Үндсэн хуулийг шинэчлэх шаардлагатай гэж үзвэл Италийн парламентын дээд танхим болох Сенатыг өөрчилж, одоогийн 315 суудлыг 100 болгон бууруулж, хууль батлах эрх мэдлийг зөвлөх, санал гаргах хэмжээнд хүртэл хязгаарлаж нэг танхимаар хууль баталдаг системтэй болох юм байна. Харин “Үгүй” гэсэн санал давамгайлбал Ерөнхий сайд Маттео Ренци албан тушаалаасаа огцрох байв. Иймээс сонгуулийн үр дүн нэгэнт ойлгомжтой болмогц Италийн Ерөнхий сайд Ром хотод хэвлэлийн хурал зарлаж, ялагдлаа хүлээн зөвшөөрсний зэрэгцээ харуцлагаа хүлээн албан тушаалаасаа огцорч буйгаа зарласан юм. Тэрбээр энэ үеэр “Засгийн газар дахь миний үүрэг харуцлага үүгээр дууслаа” гэж хэлжээ. Мөн Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэх хугацаанд дахь сүүлчийн Засгийн газрын хуралдааныг өчигдөр нээж, энэ үеэр Ерөнхийлөгч Сергио Маттареллад

## МАТТЕО РЕНЦИГИЙН ЭРИН ҮЕ ДУУСЛАА

огцрох хүсэлтээ өргөн барихаа мэдэгджээ. Маттарелла Ерөнхийлөгчийн хувьд шинэ Засгийн газар байгуулах зохицуулалт хийх төлөвлөгөөтэй байгаа аж. Гэхдээ түүний эл зохицуулалт бүтэлгүйтсэн тохиолдолд сонгууль хугацаанаасаа өмнө зарлагдах учиртай. Үндсэн хуулийг шинэчлэх талаарх Маттео Ренцигийн санаачлагыг “Таван од хөдөлгөөн” тууштай эсэргүүцэж байсан. Тийм ч учраас италичууд Ерөнхий сайддаа “Үгүй” гэж хэлсэн нь эсрэгээр Таван од хөдөлгөөнийхны хувьд ялалт болж байгаа юм. Италийн түүхэнд бүх нийтийн санал асуулга ердөө хоёр удаа буюу 1946 онд хаант засгийн хэлбэрийг хадгалах асуудлаар, 1989 онд Европын парламентын сонгуулийн үеэр болжээ. Олон улсын шинжээчдийн үзэж буйгаар Италид “Таван од” хөдөлгөөн нь тус улсын ихэнх бүс нутагт нөлөөгөө тэлсээр байгаа гэнэ.

Тэгвэл энэ удаагийн бүх нийтийн санал асуулгын дараа Таван од хөдөлгөөний тэргүүн ч мөн мэдэгдэл хийж, нэг долоо хоногос ихгүй хугацаанд ээлжит бүс сонгууль явуулахыг шаарджээ. Гэхдээ шинжээчид М.Ренцигийн тэргүүлэгч эрх баригч Ардчилсан нам түр засгийн газар байгуулж, 2018 оны хавар болох сонгууль хүртэл үйл төрийн үйл хэргийг тасалдуулалгүй үргэлжлүүлэх төлөвтэй байгааг онцолж байна. Харин түр Засгийн газрын тэргүүнээр өргөмжлөл магадлал хамгийн өндөр байгаа эрхмээр өнөөгийн сангийн сайд Пиетро Карло Падоан нэрлэгдэж байгаа юм. Учир нь хэрэв энэ үед сонгуулийг явуулбал, Таван од хөдөлгөөн нам ялах магадлал өндөртөйд тооцогдож байгаа. Хэрэв тус нам ялбал, Итали Европын холбооноос гарах асуудал сөхөгдөж эхлэх билээ.

## ШИНЭ ЗЕЛАНДЫН ДАРААГИЙН ЕРӨНХИЙ САЙД ХЭН БЭ



...Жон Ки Ерөнхий сайдын албан тушаалд гурван удаа сонгогдон ажилласан туршлагатай улстөрч. Тэрбээр эхнэр Бронатайгаа 1984 онд гэрлэж, хоёр хүүхдийн эцэг, эх болжээ. Түүний хүү Макс Ки дижэй, моделиор ажилладаг бол, охин Стефани Ки нь урлагийн чиглэлээр сурдаг аж...

Шинэ Зеландын Ерөнхий сайд Жон Ки ар гэрийн шалтгааны улмаас албан тушаалаасаа огцорч буйгаа мэдэгдлээ. Тус улсын эрх баригч Үндэсний намыг тэргүүлж, улмаар найман жилийн турш Ерөнхий сайдын албыг хашсан тэрбээр албан тушаалаасаа буух болсон нь улс төрийн хүрээллийнхний хувьд гэнэтийн мэдээ байв. Хэвлэлийн бага хурал зарлаж, энэ тухайгаа зарласан Жон Ки “Эдүгээг хүртэл гаргаж байсан шийдвэрээс хамгийн хүнд нь байлаа. Цаашдаа яах тухайгаа төлөвлөсөн зүйл алга” гэж ярьжээ. Тэрбээр эхнэрийнхээ ятгалгаар дээрх шийдвэрийг гаргасан хэмээн зарим эх сурвалж онцолж байна.

Тэрбээр 2006 онд Үндэсний намыг тэргүүлж, 2008 оноос Засгийн газрыг удирдсан юм. “10 жилийн турш төрийн эрхийг барина гэдэг их удаан хугацаа. Миний албан тушаал, хийдэг үйл ажиллагаанууд хамгийн хүндтэй хүмүүс болох гэр бүл, ойр дотныхонд минь шахалт, дараа болж байгааг удаан хугацаанд ажиглалаа. Аавынх

нь ажил хүүхдүүдэд нь дарамт болоосой гэж хүсэхгүй байна” хэмээн мэдэгдэл хийх үеэрээ хэлжээ. Жон Ки хэдийнэ Ерөнхий сайдаас огцорсон ч парламентын суудалд хэвээр үлдэх юм.

Жон Ки Ерөнхий сайдын албан тушаалд гурван удаа сонгогдон ажилласан туршлагатай улстөрч. Тэрбээр эхнэр Бронатайгаа 1984 онд гэрлэж, хоёр хүүхдийн эцэг, эх болжээ. Түүний хүү Макс Ки дижэй, моделиор ажилладаг бол, охин Стефани Ки нь урлагийн чиглэлээр сурдаг аж. Жон Кигийн гэнэтийн мэдэгдлийн дараа түүний залгамжлагчийн тухай яригдаж эхэллээ. Жон Кигийн хувьд хэн ч сонгогдсон дэмжихээ илэрхийлсэн юм. Эрх баригч Үндэсний намын

ээлжит хурал ирэх долоо хоногт болох бөгөөд энэ үеэр шинэ намын тэргүүнийг томилох юм байна. Гэхдээ аль хэдийнэ Намын дарга болон Шинэ Зеландын дараагийн Ерөнхий сайдад нэр дэвших магадлал өндөртэй эрхмүүдийн нэрс тодорч эхэллээ.

Билл Инглиш

Албан тушаалаасаа огцорч буйгаа зарласан Ерөнхий сайд Жон Ки хэн ч сонгогдсон дэмжихээ илэрхийлсэн хэдий ч, өнөөгийн Сангийн сайд Билл Инглишийг 2017 оны сонгуульд ялах магадлалтай тухай саналаа хэлсэн байх юм. Билл Инглишийн хувьд

өмнө нь Үндэсний намын дарга байсан бөгөөд 2002 оны сонгуульд намаа удирдан оролцоходоо ялагдал хүлээсэн байдаг. Харин 2008 оноос Шадар сайд, Сангийн сайдын үүргийг гүйцэтгэж, эдийн засгийн чиглэлээр дорвитой үйл ажиллагаа явуулж иржээ. Билл Инглишийг улс төрөөс ангид ойлгох боломжгүй. Учир нь тэрбээр 1990 оноос хойш парламентад иргэдийг төлөөлж эхэлсэн бөгөөд түүнээс хойш Дэд бүтцийн сайд, сөрөг хүчний тэргүүн, Сангийн сайд гэх мэт томоохон албан тушаалыг хашиж байлаа. Тиймээс Үндэсний нам доторх түүний дэмжлэгийг дутуу үнэлж болохгүй юм.

Паула Беннетт

Үндэсний намын гишүүн Паула Беннеттын нэр ч дараагийн Ерөнхий сайдын сунгаанд яригдаж эхэлжээ. Тэрбээр 2014 оны сонгуульд ялалт байгуулж, парламентад сонгогдсон бөгөөд Засгийн газрын хэд хэдэн чухал сайдын албыг хашиж явсан туршлагатай нэгэн. Тодруулбал, Уур амьсгалын өөрчлөлт харуцсан сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд гэх мэт харуцлагатай албыг хашиж явжээ. Үүнээс гадна ганц бие ээж гэдгээ тэрбээр онцолдог байна.

Стивен Жойс

Шинэ Зеландын Ерөнхий сайд болж, магадгүй эрхмийн

жагсаалтыг Стивен Жойс үргэлжлүүлж байна. Түүний хувьд Билл Инглишийн тун хүндхэн өрсөлдөгчийн нэг гэж тодорхойлж болох юм. Учир нь Стивен Жойсын хоч нь “Бүх салбарын сайд”.

Өнөөгийн намын дарга Жон Кигийн ойрын хүн гэдгээрээ танигдсан эрхэм бөгөөд бизнесийн салбарт дэмжлэг сайтайд тооцогддог байна. Түүний туршлагыг харвал, 2011 онд Эдийн засгийн хөгжлийн сайд, Хөдөлмөр эрхлэлт, боловсролын сайд, Зам тээврийн сайд, Мэдээлэл технологи харилцаа холбооны сайд, Шинжлэх ухаан инновацийн сайд гэх мэт бүхий салбарын сайдын үүргийг гүйцэтгэж явжээ. Одоогоор түүнд Ерөнхий сайдын суудалд томилогдох л үлдээд байна.

Эми Адамс

Одоогоор дараагийн шинэ Ерөнхий сайдад нэр дэвших магадлал өндөртэй хүмүүс дундаа сул улстөрчид тооцогдох хэдий ч, нэлээд том тоглогчдын нэг нь Эми Адамс. Тэрбээр 2016 оны шилдэг улстөрчөөр нэрлэгдсэнээс гадна саяхан Хууль зүйн сайдаар томилогдсон юм. Гэхдээ Жон Кигийн танхимд 2008 оноос орж ажилласан байх бөгөөд Байгаль орчны сайдаар ажиллаж эхэлжээ. Түүний хувьд ажилласан туршлага хэдийгээр бага ч нам дотроо нэр хүндтэй гэдгийг эх сурвалжууд онцолж байна.



Тал нутгийн цахим мэдээлэл



# STRESS

Оддын Цаг

## Мерил Стрип:

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Асар их доромжлол, доог тохууг үл тоон сапфон дуучин болох хүүхэд насны мөрөөдлөө биелүүлж чадсан алдартай дуучин Флоренсын тухай бодит амьдралаас сэдэвлэсэн "Florence Foster Jenkins" кино энэ онд нээлтээ хийсэн. Түүхч Стивен Пил Флоренсыг бүх цаг үеийн хамгийн муу дуурийн дуулаач хэлтэн нэгэнтээ дурьдсан байдаг. Гэсэн хэдий ч, түүний ур чадвар 1920, 30, 40-өөд оныхныг байлдан дагуулж байсан гэдэг. Уг кинонд 19 удаа Оскарт нэр дэвшсэн чадварлаг жүжигчин Мерил Стрип тоглосон юм. Харин нэрт жүжигчин уг уран бүтээлийнхээ тухай хэрхэн өгүүлснийг "Оддын цаг" буланд да орчуулан хүргэж байна.

**-Карнеги холд танхим дүүрэн үзэгчдийн өмнө гарч дуулж буй хэсгийн зураг авалтыг хэрхэн хийсэн бэ?**

-Тэр хэсгийн зургийг тус тусад нь авсан. Эхлээд тайзан дээр дуулж буй жүжигчний зургийг авч, харин дараа нь үзэгчдийн хэсгийн авсан. Тэр үед найруулагч Стивен Фрирэд "Эхлээд үзэгчдийн зургийг авбал ямар вэ. Тэгвэл жинхэнэ тоглолт шиг болох биш үү" гэж хэлж үзсэн л дээ. Үзэгчид бидний юу үзүүлэхийг мэдээгүй байсан. Угаасаа хэлээгүй юм чинь. Зүгээр л нэг танхимд оруулж ирээд, чимээгүй суулгачихсан. Тэгээд тал бүрээс нь таван камер зургийг нь авсан даа. Тиймээс кинон дахь үзэгчдийн сэтгэл хөдлөл их өвөрмөц байх болно. Харин миний



шархлуулахгүйн тулд түүний талаархи шүүмжүүдийг нуудаг. Гэтэл үнэн хэрэгтээ Флоренс ч гэсэн Сент Клэйрын төлөө адил зүйл хийх нь бий. Энэ мэтээр хоёр хүний хоорондын нандин харилцааг гаргахдаа Хью тун ч дур булаам харагдаж билээ?

-Сент Клэйр, Флоренс нар 30 жил хамтдаа амьдарсан төдийгүй нэг нэгийгээ дэмжигч байсан. Хьютай энэ бүтээл дээр л анх удаа хамтран ажиллаж байна. Зураг авалт эхлэхээс өмнө киноны продюссер биднийг гэртээ оройн зоогт урьж, улмаар тэдний 30 жилийн турш нэг нэгэндээ бичсэн захидлыг үзүүлж билээ. Сент Клэйрын Флоренсын төлөө гэсэн сэтгэл хайр уу, аль эсвэл мөнгөний төлөө юу гэх мэт эргэлзээтэй асуулт олон байгааг мэдэж байсан ч, тэдгээр захидлын талаар юу ч мэдээгүй байв. Гэтэл захидлаас хайр гэрэлтэж байсан. Хью хайр ч гэсэн хувийн ашиг сонирхол гэж хэлж билээ. Үгүйсгэх аргагүй. Гэхдээ тэдний хоорондын харилцааг хайр сэтгэл гэж хэлэх нь зүйтэй байх.

**-Энэ бүтээлд тоглохдоо дуулахаас эхлээд, Флоренсын сэтгэл хөдлөлийн талаар ч судалсан уу?**

-Жүжиглэхдээ би өөрийгөө судалдаг. Учир нь ингэхдээ өөрийнхөө өөр нэг хэсэг рүү нэвтэрдэг учраас тэр. Энэ удаа би ямар нэг зүйлийг буруу хийсэн эсэхдээ хэт анхаардаг гэдгээ мэдсэн. Ер нь би байнга хаана алдаа гаргаж гэдгээ ажиглаж явдаг. Тэр нь миний сул тал байх. Гэхдээ үүнээс үл хамааран, цор ганц дэлхийн хамгийн гайхалтай, үзэгсэлтэй бүсгүйг хүмүүст харуулахыг хүслээ. Флоренсын өөдрөг үзэл, муу муухайг ч үл тоох зан араншин нь

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -10  
Шөнө -24  
Нөгөөдөр  
Өдөр -14  
Шөнө -24

### Өдрийн зурхай

**Өвлийн дунд цагаан хулгана сар есөн Улаан мэнгэтэй хар нохой өдөр**

Наран ургах шингэх: 08.27-17.00

Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ



Тухайн өдөр тогой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналтаг хандаж, бие энхрийлүүштэй. Эл хараал давах, гал мандал хий ээрэт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал айлшиг болох, зүүн чих жингэнээвэл жуулчин ирэх, хэрэ дуугарвал зочин ирэх, тагнай заатанал атлалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэлцэл болно. Өдрийн сайн цаг нь бар, луу, тогой, бич, тахиа, гахай болой.

## Зан араншин нь ээжтэй минь төстэй учраас ФЛОРЕНСТ татагдсан

зураг авалт дунджаар оройн 21:00 цагт дуусч байв. Ядарч, сульдсанаас гадна хоолой ч авах юмгүй болсон. Даваа, мягмар гарагт бүтэн, лхагва гарагт өдрийн хагас зураг авсан. Киноны зураг авалт дууссаны дараа Нью-Йоркт очиж, сапрон дуучин Рене Флемингтэй уулзав. Гэтэл надаас "Шөнийн хатан хааны ари"-г нэг өдөрт хоёр удаа дуулж байна уу" гэж асуухад нь "Нэг өдөрт найм шүү дээ" гэж

хариулсан юм. Гэтэл "Би долоо хоногт хоёр л удаа дуулдаг. Түүнээс дээш дуулж чадах хүн бараг байхгүй дээ" гэж билээ. Зураг авалтын үеэр бүгд л надад санаа тавьж байсан. Гэхдээ хоолойгоо амраахын тулд хагас өдөр амраад, үргэлжлүүлээд зураг авалт руугаа шилжиж байсныг хэлэх хэрэгтэй.

**-Үнэхээр гайхалтай тоглолт болсон?**  
-За баярлалаа, гэхдээ их

хөгжилтэй байж билээ. /инээв/

**-Оскарт 19 удаа нэр дэвшсэн жүжигчинтэй хамт кинонд тоглохдоо айсан гэж Хью Грант ярьсан байна билээ?**

-Итгэмээргүй юм. Би тийм аймаар биш шүү дээ. Хэрвээ үнэн бол их л хөгжилтэй байсан бололтой.

**-Гэхдээ жүжигчдэд нийтлэг тохиолддог байх?**

-Магадгүй юм. Гэхдээ Хью тэгж хэлсэн гэхэд итгэмээргүй. /инээв/. Яах вэ залуу жүжигчидтэй хамтран тоглоход тийм тохиолдол байх. Гэвч ажлаа хийж байхад ямар нэг хүндрэл гардаггүй. Ер нь жүжиглэлт гэдэг тухайн хоёр жүжигчин өөр хоорондоо хэрхэн нийцж буйгаас хамаардаг учраас аль болох хамтдаа тэрхүү ханыг нураах л хэрэгтэй.

-Сент Клэйр Флоренсыг

миний ээжтэй төстэй санагдсан болохоор л түүнд татагдсан юм. Ийм хүмүүс амьдралаас аз жаргалыг мэддэг. Харин эсрэгээрээ над шиг хүмүүс ямар нэг зүйлийг буруу хийсэн эсэхдээ хэт анхаарч, өөрийгөө шанаалгаж байдаг.



### ДУУЛГАХ СОНИН

#### Мисс А.Баярцэцэгт "Мулан"-ы дүрд шалгуулах санал тавьжээ

Б.ЗАЯА

Дэлхийн хамгийн үзэсгэлэнтэй, гоо бүсгүйг шалгаруулдаг "Miss World" тэмцээн АНУ-ын Вашингтон хотноо үргэлжилж байна. Тус тэмцээнд "Торго модель" агентлагийн загвар өмсөгч,

мисс А.Баярцэцэг оролцож, эх орноо төлөөлж буй юм. Тэгвэл түүнд Сан Франциско дахь агентлагаас "Уолт Дисней" компанийн хийж буй "Мулан" уран сайхны кинонд шалгуулах хүсэлт тавьсан байна. Одоогоор дээрх хүсэлтийн дагуу мисс А.Баярцэцэг өөрийн

портфолиогоо тус агентлагт явуулаад байгаа гэнэ. Дашрамд дурьдахад, загвар өмсөгч, мисс А.Баярцэцэг хүсэл мөрөөдлөө биелүүлэхээр кино урлагт хөл тавьж, АНУ-ын "Netflix" компанийн бүтээл "Марко Поло" кинонд туслах дүр бүтээсэн нэгэн билээ.

### Бидэнд тохиолдсон

Хүндэн хөгтэй явдлууд



### Дэлэн Дэки

Эгчийн хүүхдүүд ёлкоо зассан гээд өвлийн өвөөд бичих захианыхаа талаар ярилцаж байна. Би энэ жил өвлийн өвөө хямралтай байгаа даа, нийгэм хямралтай байгаа гэсэн чинь том охин нь "Хямарна гэж юу гэсэн үг вэ" гэж асуулаа. Би "Мөнгө муутай болохоор жижиг жижиг л бэлэг өгөх байх даа" гэтэл охин "Өө тэгвэл өнгөрсөн жил хямарчихсан байсан юм уу. Baby-bop хулхи байсан" гэдэг юм даа. Уг нь тэр нь идэж ууна, арьс нь ч тэр оргил байсан юм. Хүүхдүүд ээ гэж ээ.

Advertisement for TENGIS featuring Underworld: Blood Wars, Sing, Assassins Creed, and various offers like 2000 TUG and 3000 TUG.